



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/319

Есөнбулаг сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалт, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 19-ний 001/ХТ2024/000324 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Намширын Алтанхуягийн орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 8208004904 нэгж талбарын дугаартай 452м² газрыг шилжүүлж авсан иргэн Рэнцэнсамбуугийн Сандуйбаатарын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 0735 дугаартай нотариатын гэрээг Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 19-ний 001/ХТ2024/000324 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул аймгийн Засаг даргын 2023 оны А/487 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2. Захирамжийг газрын кадастрын системд бүртгэн, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ж. Мянганбаяр)- т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

